



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Бэрх тосгоны Захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2023/22/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Чингис хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Аудитор: Н.Туяа

Утас: 99799709

Цахим хаяг: www.open.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сэриг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.04.04 № 315

танай _____ -ны № _____ -т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ
ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Ч.ЭНХЖАВХЛАН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Бэрх тосгоны Захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Бэрх тосгоны Захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бэрх тосгоны Захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 351,443.7 мянган төгрөг, авлага 159,445.9 мянган төгрөг, бараа материал 76,016.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,387,183.5 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 2,974,089.6 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 749,911.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, 401,373.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 1,162,545.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 60,552.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 36,423.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Бэрх тосгоны Захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 23,725.3 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

232330415

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах, төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн хамт бэлтгэж ирүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		999,677.10	586,906.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	252,359.20	351,443.70
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	448,339.20	159,445.90
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	287,736.60	67,252.30
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	11,242.00	8,764.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		10,065,830.70	2,387,183.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	10,065,830.70	2,387,183.50
39200	Биет хөрөнгө		9,729,832.40	2,084,804.40
39300	Биет бус хөрөнгө	13	335,998.20	302,379.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		11,065,507.70	2,974,089.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		11,065,507.70	2,974,089.60
51	Засгийн газрын хувь оролцоо		11,065,507.70	2,974,089.60
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,346,992.90	314,956.50
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		0	314,956.50
51200	Хуримтлагдсан үр дүн		5,659,854.40	2,329,085.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		4,058,660.40	330,047.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		11,065,507.70	2,974,089.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		5,411,788.20	1,492,378.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО		130,770.40	326,674.50
110	Орлогын албан татвар		82,117.00	263,736.70
1100	Хувь хүний орлогын албан татвар		82,117.00	263,736.70
113	Хөрөнгийн албан татвар		26,517.50	38,277.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж		22,135.80	24,660.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,353,900.80	326,947.40
120	Нийтлэг татварын бус орлого		1,353,900.80	326,947.40
121	Хөрөнгийн орлого		0	0
122	Тусламжийн орлого		0	0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		0	0
124	Зээлийн орлого		0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,927,117.10	838,756.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,150,209.00	1,341,589.40

21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,150,209.00	1,341,589.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,619,560.40	1,322,684.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,771,139.80	248,362.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		228,799.30	31,142.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		615,511.40	655,229.00
2104	Хангамж, бараа материалын зардал		80,069.10	22,604.60
2105	Нормативт зардал		222,545.30	1,330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		22,217.90	30,970.10
2107	Томилот, зочны зардал		11,289.50	3,571.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		35,534.10	84,311.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		632,454.10	245,162.50
211	ХҮҮ		0	0
212	ТАТААС		0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		530,648.60	18,905.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,261,579.20	150,788.70
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		6,739.20	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		133,165.90	8,085,111.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,135,152.50	-7,934,322.80

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,038,475.60	1,390,937.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	130,770.40	326,674.50
110	Орлогын албан татвар	82,117.00	263,736.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	82,117.00	263,736.70
113	Хөрөнгийн албан татвар	26,517.50	38,277.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	22,135.80	24,660.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,107.00	24,330.40
1181	Газрын төлбөр	28.8	329.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	183,988.60	208,371.90
120	Нийтлэг татварын бус орлого	183,988.60	208,371.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,723,716.60	855,890.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,628,064.20	1,191,041.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,628,064.20	1,191,041.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,038,427.60	1,063,276.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,771,139.80	248,362.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,643.00	31,196.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	611,759.30	655,229.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,627.80	23,100.60

2105	Нормативт зардал	206,376.90	1,615.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,695.20	31,131.90
2107	Томилолт, зочны зардал	11,289.50	3,571.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,498.20	36,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,398.00	32,729.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	589,636.60	127,764.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	410,411.40	199,895.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	182,741.60	100,811.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	182,741.60	100,811.30
2200	Дотоод эх үүсвэрээр	182,741.60	100,811.30
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-182,741.60	-100,811.30
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-81,500.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	81,500.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	146,169.80	99,084.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	106,189.50	252,359.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	252,359.20	351,443.70

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	9,016,059.50	9,016,059.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	921,034.90	921,034.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,937,094.40	9,937,094.40
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	-6,739.20	-6,739.20
8	Зарласан ногдол ашиг	0	0
9	Тайлант үеийн үр дүн	1,135,152.50	1,135,152.50
10	2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	11,065,507.70	11,065,507.70
11	2022 оны 1-р сарын 1-ээр үлдэгдэл	11,065,507.70	11,065,507.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-240,673.30	-240,673.30
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,824,834.40	10,824,834.40
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	83,578.00	83,578.00

16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0
19	Тайлант үеийн үр дүн	-7,934,322.80	-7,934,322.80
20	2022 оны 12-р сарын 31-аар үлдэгдэл	2,974,089.60	2,974,089.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,399,738.7	1,130,092.8	269,645.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,110,581.9	1,050,029.5	60,552.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,094,296.0	1,033,744.2	60,551.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,391.9	242,437.9	33,954.0
210101	Үндсэн цалин	195,105.3	158,412.4	36,692.9
210102	Нэмэгдэл	33,654.9	34,862.4	-1,207.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,024.0	1,906.8	1,117.2
210104	Урамшуулал	0.0	6,774.1	-6,774.1
210105	Гэрээт ажлын хөлс	44,607.7	40,482.2	4,125.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,705.0	30,445.1	4,259.9
210201	Тэтгэврийн даатгал	23,608.7	21,688.5	1,920.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,774.0	2,277.1	496.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,220.1	1,781.4	438.7
210204	Ажилгүйдлийн даатгал	554.5	427.1	127.4
210205	Эрүүл мэндийн даатгал	5,547.7	4,271.1	1,276.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	672,624.2	653,951.2	18,673.0
210301	Гэрэл, цахилгаан	43,015.4	39,089.9	3,925.5
210302	Түлш, халаалт	606,981.6	599,439.4	7,542.2
210303	Цэвэр, бохир ус	22,627.2	15,421.8	7,205.4
210304	Байрны түрээс	18837.7	18453.9	383.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,206.5	2,331.0	-124.5
210401	Бичиг хэрэг	11,240.0	11,233.0	7.0
210402	Тээвэр, шатахуун	2,944.0	2,421.5	522.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.0	50.0	-50.0
210404	Ном, хэвлэл	2,447.2	2,418.5	28.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1615.3	1615.2	0.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,615.3	1,615.2	0.1
2105	Нормативт зардал	24,342.3	24,294.0	48.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11960	11960	0.00
210502	Хоол, хүнс	36.8	36.8	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,345.5	12,297.2	48.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,575.3	3,571.5	3.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,575.3	3,571.5	3.8
210602	Тавилга	42422.8	41707.1	715.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,746.2	40,675.4	70.8
210604	Урсгал засвар	532.6	0.0	532.6
2107	Томилолт, зочны зардал	511.9	463.9	48.0
210701	Гадаад албан томилолт	261	258.318	2.68

210702	Дотоод албан томилолт	89.5	89.5	0.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	250	220	30.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31.6	0.0	31.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,781.5	17,268.3	2,513.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,014.0	16,501.3	2,512.8
210803	Даатгалын үйлчилгээ	767.5	767.1	0.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	16,285.9	16,285.3	0.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	16,285.9	16,285.3	0.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,653.3	11,653.3	0.0
210807	Газрын төлбөр	4,632.6	4,632.0	0.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	109156.8	80063.3	29,093.50
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	109156.8	80063.3	29,093.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,000.0	0.0	180,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	180,000.0	0.0	180,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,399.7	1,203.6	196.1
211	ХҮҮ	1,184.39	1,171.5	12.84
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,114.83	1,102.0	12.84
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	69.55	69.6	0.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	215.35	32.1	183.30
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	70.73	31.8	38.93
212	ТАТААС	0.25	0.3	0.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	144.37	-	144.37
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	145.2	-145.22
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	195.0	-195.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,285.9	16,285.3	0.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,285.9	16,285.3	0.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653.3	11,653.3	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,632.6	4,632.0	0.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	109,156.8	80,063.3	29,093.5
223001	Бусад хөрөнгө	109,156.8	80,063.3	29,093.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	180,000.0	-	180,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	180,000.0	-	180,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,399,738.7	1,203,601.8	196,136.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,184,386.7	1,171,547.9	12,838.8
320001	Орон нутгийн төсвөөс	1,114,831.9	1,101,993.1	12,838.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	69,554.8	69,554.8	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	215,352.0	32,053.9	183,298.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,734.0	31,803.9	38,930.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250.0	250.0	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	144,368.0	-	144,368.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	121,497.0	-121,497.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	195,006.0	-195,006.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,423.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,423.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,105.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,277.8
210301	Гэрэл, цахилгаан	1,277.8
2104	Хангамж, бараа материалын зардал	262.0
210401	Бичиг хэрэг	262.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	541.7
210604	Урсгал засвар	541.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,562.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,402.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	160.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,461.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,461.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,318.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,250.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,250.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,068.3
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,068.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,423.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,423.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,898.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,525.3

5.1 Тус тосгоны харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Бэрх тосгоны Захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн байгууллагын 1, төрийн сангийн 1, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 1, тусгай сангийн 2, нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Захирагчийн ажлын алба, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Бэрх тохижилт ОНӨААТҮГ, 1 төрийн сан аудитын түүвэрт хамрагдсан болно.

Харьяа орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,020.0 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илрүүлснээс 1,020.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Бэрх хөгжил ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулаагүй, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлж ажиллаагүй байна.

1. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.1 дэх "1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн

3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.” 2.Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараах зүйлийг тусгана: 1/байгууллагын 3 жилийн хэтийн зорилт; 2/үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ; 3/нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулахад баримталсан бодлогын тухай тайлбар; 4/санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг; 5/төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг; 6/төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

5.2. Тус тосгоны харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Бэрх тосгоны Захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа улсын төсвийн 4 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 төсвийн байгууллагын тайланд аудит хийж дүгнэлт гарган, Соёлын ордон аудитын түүвэрт хамрагдсан болно.

Аудитад хамрагдсан ЕБС-ийн санхүүгийн тайланд аймаг дахь Төрийн аудитын газар, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд “Платиниум прогресс аудит” ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 454,138.9 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлснээс 7,717.3 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,624.4 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 444,267.2 мянган төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Соёлын ордон 400.0 мянган төгрөгийг ажилтнуудын хүүхдийн бэлэг худалдан авахад зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.5. “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Соёлын ордон тайлант онд батлагдсан төсвөөр 10 орон тоотой батлагдсанаас 10 дугаар сарын 01-ээс 11 орон тоотой буюу жолоочийн 1 орон тоог нэмж ажиллуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3. “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3. Соёлын ордон Хас эрин ХХК-иас санхүүгийн программ худалдан авахаар гэрээний дагуу 1,500.0 мянган төгрөгийг шилжүүлээд хөрөнгийг хүлээлгэн өгөөгүй байхад орлогоор бүртгээсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

4. ЭМТ нь нэг албан хаагчид илүү цагийн хөлс, нэмэгдэл цалинг 751,4 мянган төгрөгөөр илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1 дэх “Ажил олгогч нь ажилтантай тохиролцооноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан

тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”-ыг зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

5. ЭМТ нь албан хаагчдад албан томилолтын зардлыг 473.0 мянган төгрөгөөр илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6 дахь “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4 дэх “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцсан ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” –г тус тус зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

6. ЭМТ томилолтын зардлыг Сангийн сайдын 2022.06.02-ны өдрийн №120 дугаар тушаалаар албан томилолтын зардлын тариф шинэчлэгдсэнтэй холбоотой өмнөх оны гүйцэтгэлээс 530,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн зарцуулсан байна. Энэ нь “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 15.2.3 дахь “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх,” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

1. ЭМТ нь шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 24,800.0 мянган төгрөгийн зарлагын 2 мөнгөн гүйлгээ, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 417,758.0 мянган төгрөгийн 35 тушаал шийдвэрийг тус тус мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй нь “Шилэн дансны тухай хууль”-ийн 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 6.8.1 дэх “тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр” гэсэн заалтуудыг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

2. ЕБС үндсэн хөрөнгийн элэгдлийг санхүүгийн тайланд 831.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

3. Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайланд зардлуудыг зөрүүтэй илэрхийлсэн 5,386.2 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

5.3 Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 23,725.3 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэхдээ ЭМТ-ийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг 23,725.3 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэснийг залруулсан.

Аудитаар зөрчил илрээгүй.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг дарга	1	23725.3			1	23725.3	1	23725.3				
Дүн	1	23725.3			1	23725.3	1	23725.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бэрх хөгжил ОНӨААТҮГ	1	0					1	0				
Дүн	1	0					1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
ЗАА	1	1020.0	1	1020.0						
Дүн	1	1020.0	1	1020.0						
Нийт дүн	1	1020.0	1	1020.0						

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	5	3	2		3			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	3		3					
4	ОНӨААН	1		1					
5	ТЕЗ								
	НИЙТ	9	3	6		3			